



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 1118

Чойбалсан

Ажлын хэсгийг шинэчлэн байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 11 дүгээр зүйлийн 11.1, Коронавируст халдвар /Covid-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23, Улсын Онцгой комиссын даргын “Коронавируст халдвар (Covid-19)-ын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” 2021 оны 05 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2016 оны 278 дугаар тушаал, Эрүүл мэндийн яамны 2021 оны 2/2418 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тохиолдолд (ДДУХ) ажиллах, бүртгэх, мэдээлэх, холбогдох арга хэмжээг шуурхай авах мэргэжлийн багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | | |
|----------------|----------------|--|
| Багийн ахлагч: | Ч.Оюунтунгалаг | -Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга |
| Дэд ахлагч: | Ж.Энхчимэг | -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эмчилгээ эрхэлсэн дэд захирал |
| Гишүүд: | С.Солонго | -Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн |
| | Б.Ганганцэцэг | -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдварын сэргийлэлт хяналтын албаны дарга |
| | Д.Оюунбилэг | -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Халдвартын тасгийн эрхлэгч, их эмч |
| | Б.Өнөболд | -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэс заслын тасгийн эрхлэгч, их эмч |
| | С.Дэлгэржаргал | -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Мэдээгүйжүүлэлт, эмчилгээний тасгийн эрчимт эрхлэгч, их эмч |
| | А.Баяржаргал | -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Дотрын тасгийн их эмч |

М.Жигжидсүрэн

-Бүсийн оношилгоо эмчилгээний
төвийн Мэдрэлийн тасгийн
эрхлэгч, их эмч

-Өрх, сумын Эрүүл мэндийн
төвийн дарга нар

2.Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед тандалт судалгаа хийж, дүгнэлт гарган холбогдох байгууллагад мэдээлж ажиллахыг багийн ахлагч, Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ч.Оюунтунгалагт/-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төв /Б.Сарнай/-д даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/08 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Ч.ОЮУНАА